



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 193

Улаанбаатар хот

Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг шинэчлэн бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Амар даатгал” ХХК-ийн “Гадаадад зорчигчийн иж бүрэн даатгал”-ын бүтээгдэхүүнийг хавсралтад дурдсаны дагуу шинэчлэн бүртгэсүгэй.

2. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “... Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Амар даатгал” ХХК /Т.Батзул/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын 1-д заасан бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Амар даатгал” ХХК /Т.Батзул/-д анхааруулсугай.


4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



Санхүүгийн зохицуулах хорооны
2020 оны ᠒᠔ дүгээр сарын ᠒᠒-ны
өдрийн 19᠑ дугаар тогтоолын хавсралт



Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Амар даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Гадаадад зорчигчийн иж бүрэн даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал
4.	Даатгалын зүйл	Гадаадад зорчигч иргэдийн амь нас, эрүүл мэнд
5.	Даатгалын эрсдэл	- Гэмтэл - Өвчлөл
6.	Даатгалын гэрээний хугацаа	<ul style="list-style-type: none"> • 4 хоног • 7 хоног • 10 хоног • 14 хоног • 21 хоног • 31 хоног • 45 хоног • 65 хоног • 92 хоног • 6 сар • 9 сар • Бүтэн жил
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	12 бүлэг, 158 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	“Амар даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн ЗТ-19/11-018 тоот тушаал
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Д.Уранцэцэг
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Т.Билгүүн, Х.Анхилуун